



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

### Уралдаан тэмцээний ахлагчаар томилон ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/153 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. ОХУ-ын Нижний Новгород хотод 2018 оны 04 дүгээр сарын 14-22-ны өдрүүдэд зохион байгуулагдах сагсан бөмбөгийн "Кэс-Баскет" супер финалын олон улсын тэмцээнд оролцох Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сагсан бөмбөгийн 27 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчдын ахлагчаар Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны Спортын хөгжлийн хэлтсийн дарга С.Саранцэцэгийг томилон ажиллуулсугай.

2. Уралдаан тэмцээний ахлагчаар ажиллахад шаардагдах төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд оролцоход шаардагдах онгоцны тийз, визний хураамж, томилолтын зардал нийт 3.586.740 /гурван сая таван зуун наян зургаан мянга долоон зуун дөчин/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-т зөвшөөрсүгэй.

4. Дээрх үйл ажиллагаанд томилогдон ажилласан талаарх тайланг ажлын 7 хоногт багтаан тайлагнаж, судалж мэдсэн туршлагаа ажил үүрэгтээ нэвтрүүлж ажиллахыг Спортын хөгжлийн хэлтсийн дарга С.Саранцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын  
хорооны даргын 2018 оны 04 сарын 03-ны  
өдрийн 11 дугаар тушаалын хавсралт



Томилолт, онгоцны билетийн зардлын төсөв

№	Зардлын нэр	Зардлын хэмжээ /төг/	Нийт зардал /төг/
1.	Улаанбаатар- Москва Москва-Улаанбаатар-1.733.700 төг Москва- Нижний Новгород Нижний Новгород-Москва -345,000 төг онгоцны тийзний зардал		2.078.700 төг
3.	Зочид буудал	150\$x3хоног=450\$	1.077,300 төг
4	Зам хоног, хоол	60\$x3хоног=180\$	430.740 төг
Дүн			3.586.740 төг